

МОНГОЛЫН ДИПЛОМАТ БОДЛОГЫН ШИНЭ СОНГОЛТ: ШАНХАЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА¹-ТАЙ ХОЛБОН АВЧ ҮЗЭХ НЬ

*Л.Лхагвасүрэн**

Монгол Улсад ШХАБ-д элсэх амин чухал эрх ашиг бий юу ?

Одоогоос 3 жилийн өмнө буюу 2002 оны 8 сард Монгол-Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун Япон улсад айлчлав. Тэрээр Токиод болсон хэвлэлийн бага хурал дээр ШХАБ-ын талаарх Монгол Улсын баримтлах чиг бодлогын талаар "...Хятад, Орос болон Төв Азийн улсуудаас бүрддэг ШХАБ-ын үйл ажиллагаанд бид итгэл найдвар тавьж байна. Ялангуяа тус байгууллага нь манай улсад ч хамаатай сэдэв болох терроризм, мансууруулах бодисын худалдаа, хүн худалдаалахтай тэмцэх зэрэг асуудлыг зорилгоо болгож байгаа тул манай улс энэ байгууллагад элсэхийг хүсч байна"² гэж мэдэгджээ.

Улмаар энэ 2005 оны 3 дугаар сарын дундуур Монгол Улсын Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил Япон улсад айлчилж, Японы Олон Улсын Асуудал Судлалын Хүрээлэн (Japan Institute of International Affairs=JIIA)-д айлчилж "Бүс нутгийн интеграци ба Монгол Улс" гэсэн сэдвээр илтгэл тавьсан юм. Илтгэгч энэ байгууллагын гишүүний хувьд энэхүү илтгэлийг сонирхож оролцсон бөгөөд сайд илтгэлийнхээ дараагаар ШХАБ-ын талаар илтгэлд оролцогчдын тавьсан асуултад ийнхүү хариулав. "Монгол Улс энэ байгууллагын үйл ажиллагаанд ажиглагчийн (Observer) статустайгаар оролцож байгаа бөгөөд цаашид тодорхой хугацаагаар энэ байр сууриа хадгалах болно" гэж мэдэгдээд "гэвч энэ байгууллага нь сүүлийн үед дан ганц улс төр стратегийн төдийгүй эдийн засаг, дэд бүтэц, нийгмийн хөгжлийн асуудалд анхаарах болсон нь бидний анхаарлыг татаж байна"³ гэж нэмж хэлэв.

Дээрх Гадаад харилцааны сайд нарын хэлсэн үгнүүдээс үүдэн, Монгол Улс энэ байгууллагад элсэх зайлшгүй шаардлага байгаа эсэх, ер нь ШХАБ нь ямар зорилго, онцлогтой байгууллага болох, түүнчлэн энэ байгууллагын зорилго, үйл ажиллагааны зарчим нь Монгол Улсын эрх ашигт нийцэх эсэх талаар бага ч гэсэн тодруулахыг хичээлээ.

Хэрэв Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулууны 3 жилийн өмнө мэдэгдсэнчлэн Монгол Улс энэ байгууллагад албан ёсоор элссэн тохиолдолд тэр нь чухам юуг илэрхийлж, Монголын Улс төрийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх вэ? Энэ бүхнийг урьдчилан тооцож зөв дүгнэлт өгөх нь өнөөдөр Монголын гадаад бодлогын хойшлуулашгүй асуудлын нэг гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл энэхүү сонголт нь хүйтэн дайн төгсгөл болж 1991

* Л.Лхагвасүрэн - Япон улсын Васедагийн Их Сургуулийн докторант

онд ЗХУ задарсанаас хойш өнөөдрийг хүртэл 10 гаруй жилийн хугацааг монголчууд хэрхэн туулж, юу хийж бүтээсэнд өгөх үнэлгээ юм.

ЗХУ задарсанаар түүний нөлөөнд байсан олон улсууд шинээр тусгаар тогтносны нэгэн адилаар Монгол Улс “жинхэнэ улгаараа тусгаар улс” болж, Азид ардчилалын тугийг анх өргөж, улмаар ардчилсан төрийн тогтолцоог үүсгэж (1992 оны шинэ үндсэн хууль), гадаад бодлогын хувьд түүхийн урт удаан хугацаанд хүсэн мөрөөдөж ирсэн эвсэлд үл нэгдсэн бие даасан гадаад бодлогыг гадаад бодлогын үндсэн чиг шугамаа хэмээн тодорхойлж (1994 оны гадаад бодлогын үзэл баримтлал) чадсан билээ.

Гэвч эдгээр нь Японы Такүшёкү их сургуулийн профессор Икэда Норихико-гийн хэлснээр “Өнгөрсөн 10 жил нь монголчуудын хувьд алдагдсан 10 жил байв уу, эсвэл шинэ эрин рүү өөдрөгөөр тэмүүлсэн 10 жил байв уу”⁴ гэдгийг харуулах учиртай түүхэн сонголттой өнөөдөр монголчууд тулгараад байна гэж тодорхойлж болохоор байна.

ШХАБ гэж чухам ямар байгууллага вэ?

1. Хятад улс яагаад Төв Азийн хамтын ажиллагааг чухалчлах болов?

Хятад, Орос болон Төв Азийн шинээр тусгаар тогтносон улсуудыг эгнээндээ нэгтгэсэн ШХАБ байгуулагдсан зорилго юу вэ? Түүний цаад учир шалтгаан юунд орших вэ? гэдгийг юуны өмнө мэдэхийг зорьё. Энэ нь Төв Азийн бүс нутгийн төдийгүй нийт олон улсын харилцааны цаашдын өрнөлтөд нөлөөлөх чухал хүчин зүйлийн нэг юм. Ялангуяа Хятад, Орос хоёр их гүрний хооронд хавчигдан орших Монгол Улсын хувьд энэ хоёр улсын талаар болон бусад гуравдагч улстай баримтлах чиг бодлогыг боловсруулахад шийдвэрлэх хүчин зүйл гэж хэлж болно.

1996 онд Хятад, Орос, Казакстан, Кыргыз, Тажикистан таван улсын төрийн тэргүүн нарын дээд хэмжээний уулзалт Шанхайд болсноос хойш энэ байгууллага “Шанхайн тав” нэртэйгээр анх байгуулагдсныг бид мэдэх билээ. Шанхайн тав анх байгуулагдах үеэс эхлэн Хятад улс ихээхэн анхаарч ирсэн бөгөөд энэ байгууллагыг Хятадын санаачилгаар бий болсон гэж хэлэх үндэстэй юм. Тэгвэл яагаад чухам Хятад улс Төв Азийн бүс нутагт анхаарах болов? Үүнд дараах гурван үндсэн шалтгааныг дурдаж болно.

Нэгдүгээрт, Хятадын эдийн засгийн хөгжлийг хурдасгаж, байгалийн баялгийн нөөцийг баталгаатай болгох. Хятад улс эдийн засгийн хөгжлийг энэ тэргүүний зорилтоо болгоод байгаа бөгөөд эдийн засагт учирч буй бэрхшээлийн нэг нь баруун болон зүүн бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн асар их ялгаа гэж хэлж болно. Шанхайн тав буюу хожмын ШХАБ-ын бүрэлдэхүүнд багтах Төв Азийн орнууд нь Хятадын баруун бүс нутгийн хөгжилд чухал хүчин зүйл, бүс нутаг юм. ШХАБ байгуулагдах урьдчилсан нөхцлийг тодорхойлсон баримт бичиг болох “Душанбейн тунхаглал”-д Хятадын “Баруун бүсийн хөгжлийн их программ”-д Төв Азийн орнуудыг

идэвхтэй оролцохыг уриалсан Хятадын уриалгыг дээрх орнууд дэмжиж байгаа нь үүнийг илэрхийлж байна.

Нөгөө талаар эдийн засгийн хөгжлийг хангахад Хятадын удирдагчдын сэтгэлийг зовоож буй асуудлын нэг бол эрчим хүчний найдвартай баталгааг бий болгох асуудал юм. Хятадын нефтийн импортын 60 орчим хувийг Ойрхи Дорнодын орнууд эзэлж байгаа бөгөөд сүүлийн үед Казакстан зэрэг ойр орчмын орнуудаас нефтийн хоолойгоор дамжуулан нефть импортлохыг зорьж байна.

Ийнхүү Хятадын “Баруун бүсийн хөгжлийн их программ”-ийн удаан хугацааны хөгжил болон эрчим хүчний нөөцийг бий болгоход Төв Азийн орнуудын хамтын ажиллагаа, уг бүс нутгийн тогтвортой байдал юунаас ч чухал хүчин зүйлсийн нэг гэж хэлж болохоор байна.

Хоёрдугаарт, Америкийн дангаар ноёрхох ноёрхлоос сэргийлэх. Хятад улс Төв Азийн орнуудтай харилцах харилцаа болон энэ бүс нутгийг чухалчлан үзэх болсон хоёр дахь шалтгаан нь Төв Ази дахь Америкийн дангаар ноёрхох ноёрхлоос сэргийлэхтэй холбоотой гэж хэлж болно. 1996 оны Япон-Америкийн хамтарсан тунхаглалыг Хятад улс Япон-Америкийн хамтын ноёрхол бий боллоо хэмээн ихээхэн сэрэмжлэх болсон. Улмаар Япон-Америк эвслийн гэрээгээ шинэчлэн бэхжүүлсэн явдлыг, Хятад улс бүс нутгийн олон талт бүтэц эвдэрч дан ганц Япон-Америкийн “Хамтын ноёрхол” тогтох боллоо хэмээн дүгнэсэн байна. Энэ үеэс хойш Хятад, Америкийн дангаар ноёрхлыг аль болох саармагжуулах шаардлагатай гэж үзсэн бөгөөд Америкийн пуужингийн системийг эрс эсэргүүцэхээ мэдэгдсэн байна.⁵

Мөн 1999 оны 4 сард НАТО “Шинэ стратегийн үзэл баримтлалаа” баталсан ба энэ үзэл баримтлал нь гишүүн орнуудын аюулгүй байдлыг хамгаалаад зогсохгүй гишүүн бус орнуудын бүс нутгийн “мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, учирсан аюулыг арилгах” хүртэл батлан хамгаалах хүрээгээ өргөтгөсөн онцлогтой юм. Энэ “Шинэ стратегийн үзэл баримтлал”-ыг Хятад улс “Хүрээгээ тэлсэн ноёрхлын шинэ үзэл баримтлал мөн” гээд шинэ аюул бий боллоо хэмээн мэдээлсэн байна.⁶

Эдгээр байдлаас үзэхэд Америкийн дангаар ноёрхох ноёрхлыг эсэргүүцэхийн зэрэгцээ НАТО-гийн дорно зүгт өргөжиж буй явдлыг хязгаарлахын тулд Хятад улс Төв Азийн орнуудтай харилцаагаа өргөтгөж байна гэж үзэж болохоор байна.

Гурав дахь шалтгаан бол салан тусгаарлагчид болон лалын экстремистүүдтэй тэмцэх явдал юм. Тухайлбал Шиньжаан Уйгурын өөртөө засах оронд салан тусгаарлагчдын хөдөлгөөн 1991 онд ЗХУ задарснаас хойш идэвхжсэн бөгөөд Төв Азид шинээр тусгаар тогтносон улсуудаас хил хоорондын худалдаагаар дамжин лалын болон лалын хэт даврагсдын нөлөө Шиньжаанд нэвтрэх болсон байна. Мөн

Шиньжаан Уйгурын салан тусгаарлагчид зэвсгийн гадны тусламж авах болжээ. Тийм учраас Хятад улс Төв Азийн улс орнуудтай харилцаагаа зузаатгаж, уг бүс нутагт олноор оршин суудаг салан тусгаарлагчдын үр нөлөөг таслах шаардлага бий болсон болов уу. Улмаар 1996 онд болсон “Шанхайн тав”-ын төрийн тэргүүн нарын анхны дээд хэмжээний уулзалт дээр Казакстаны ерөнхийлөгч Назарбаев, Кыргызын ерөнхийлөгч Акаев, Тажикстаны ерөнхийлөгч Рахмонов нар Хятадын салан тусгаарлагчдын хөдөлгөөнийг эсэргүүцэж байгаагаа мэдэгджээ.⁷

2. ШХАБ Хятад-Оросын стратегийн түншлэлийн шинэ фронт болох нь Үүнийг тайлбарлахын тулд 1996 оны 4 сард Хятад-Оросын хооронд байгуулагдсан “Стратегийн түншлэл”-ийн бүтцэд анхаарч үзэх хэрэгтэй юм. Японы эрдэмтэн Кимура Хироши Орос-Хятадын “Стратегийн түншлэл”-ийн бүтцийг дараах байдлаар тодорхойлсон байна.

1. Хятад-Оросын хооронд харилцан нэгнийгээ их гүрэн болохоос сэргийлсэн “Хоорондын аюулгүй байдлын шаардлага”, 2. Оросоос Хятадад нийлүүлэх эрчим хүч, зэвсгийн нийлүүлэлт, Хятадаас Орост нийлүүлэх хөнгөн аж үйлдвэрийн болон хэрэглээний бараа материал, ХАА-н бүтээгдэхүүн, хөдөлмөрийн хүч зэрэг “Эдийн засгийн хувьд харилцан нэгнийгээ нөхөх бодит шаардлага”, 3. Чечень, Монгол, Төвд, Тайвань, хүний эрх зэрэг “Хоорондын дотоод хэрэгт үл оролцохгүй байх эрх ашиг”, 4. Америк, Японы нөлөөг хязгаарлах гэсэн “Гадаад бодлого стратегийн эрх ашиг” бүхий пирамид хэлбэрийн олон давхар бүтэцтэй” гэж дүгнэжээ.⁸

Гэтэл энэ пирамидтай адил төстэй буюу түүний утга агуулгыг бүс нутгийн хүрээнд өргөтгөсөн хэлж болохоор бүтэц ШХАБ-д ажиглагдаж байна.

2001 оны 6 сард Хятадын төрийн тэргүүн Зянь Зэминь ШХАБ албан ёсоор байгуулагдах үед хэлсэн үгэндээ уг байгууллагын цаашдын дүр төрхийг дараах байдлаар тодорхойлов.

“Шанхайн тавын үйл явц нь өнөөгийн олон улсын харилцааны том зорилтуудын нэг бөгөөд гишүүн улсууд харилцан итгэлцэл, цэрэг зэвсэглэлийг хорогдуулах, хамтын аюулгүй байдлыг багтаасан шинэ аюулгүй байдлын үзэл баримтлалыг дэвшүүлэн тавьж, Хятад, Орос улсын хооронд үүсгэн байгуулсан харилцан түншлэл, эвслийн бус хамтын ажиллагаанд тулгуурласан улс хоорондын шинэ харилцааг хөгжүүлэхийн зэрэгцээ бүх улсууд хамтаар хүлээн зөвшөөрсөн аюулгүй байдал, харилцан хамтын ажиллагааны онцлогыг агуулсан шинэ бүс нутгийн шинэ загварыг бий болголоо”⁹ хэмээн мэдэгджээ.

Энэ бүхнээс үзвэл ШХАБ нь Хятад-Оросын “Стратегийн түншлэл”-ийн цар хүрээг бүс нутгийн хүрээнд өргөтгөх гэсэн зорилготой гэж үзэж болохоор байна. Үүнийг батлах өөр нэг жишээ бол 1996 онд Шанхайн тавын төрийн тэргүүнүүдийн анхдугаар уулзалт болохын өмнөх өдөр

Хятадад албан ёсны айлчлал хийж байсан Оросын Ерөнхийлөгч Б.Ельцин, Хятадын төрийн тэргүүн Зянь Зэминь нар “Хятад-Оросын хамтарсан мэдэгдэл”-д гарын үсэг зурж, Хятад-Оросын хоорондын “Стратегийн түншлэл”-ийн гэрээний агуулгыг өргөжүүлэхээр хоёр тал хэлэлцэн тохирсон явдал юм. Энэхүү түншлэлийн харилцааны тухай хамтарсан мэдэгдлийн агуулга нь дээр өгүүлсэн ШХАБ байгуулагдсаны дараа Зянь Зэминь-ий хэлсэн үгийн агуулгатай ихээхэн адил байгаа нь үүнийг давхар нотолж байна.

Эдгээрийн уялдаа холбоог сайтар эргэцүүлэн бодож үзвэл ШХАБ нь Хятад-Оросын хооронд байгуулсан “Стратегийн түншлэл”-ийн шууд үргэлжлэл, түүнийг бүс нутгийн хүрээн дэх практик хэрэгжилт гэж үзэж болохоор байна.

3. ШХАБ Хятадын аюулгүй байдлын шинэ бодлогын фронт болох нь Хятадын гадаад бодлого, аюулгүй байдлын үзэл баримтлалын нэг гол зарчим бол төрийн бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, дотоод хэрэгт үл оролцохыг хатуу чанд сахих явдал бөгөөд энэ зарчим нь ШХАБ-д ихээхэн нөлөөлсөн гэж үзэж болно. Эдгээр зарчим нь анх “Шанхайн тав”-ын баримт бичгүүдэд тусгагдаж байсан бол улмаар ШХАБ байгуулагдсаны дараа ШХАБ-ын тунхаглалд тусгалаа олсон юм.

Тухайлбал 1998 оны “Алм-Атын тунхаглалд”-д “төрийн бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүтэн байдал, дотоод хэрэгт үл оролцох явдлыг гишүүн улсууд чанд сахиж, энэ зарчмыг зөрчихгүй” байх тухай заасан байна.¹⁰ Мөн 1999 оны Бишкекын тунхаглалд терроризм, мансууруулах бодисын худалдаа зэрэг хил дамнасан асуудлуудыг хамтран шийдэхдээ гишүүн орнуудын төрийн бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, дотоод хэрэгт оролцохгүй байх, бусад улсын дотоодын дэг журмыг сарниулахыг хориглосон” байна.

Үүний зэрэгцээгээр гишүүн улсууд НҮБ-ын дүрэмд заасны дагуу хүний эрхийг сахин хүндэтгэх бөгөөд хүний эрхийг хамгаалах нэрийдлээр бусад улсаас дотоод хэрэгт оролцох явдлыг эсэргүүцсэн байна.¹¹ Энэ нь ШХАБ-ын гишүүн улсуудаас өөр гуравдагч улсад хандсан заалт болох нь илэрхий байна.

Дээрх заалтыг Душанбейн тунхаглалд дахин тодруулж, “НҮБ-ын дүрэмд заасны дагуу аливаа улс улс төр, эдийн засаг, нийгмийн байгууллага өөрсдөө сонгох эрхтэй бөгөөд хүмүүнлэгийн болон хүний эрхийг хамгаалах, нэрийдлээр бусад улсын дотоод хэрэгт оролцохыг эсэргүүцжээ”. Энэ агуулга нь ШХАБ-ын тунхаглалд тусгалаа олж, Шанхайн үзэл санаа (Shanghai spirit)-ны дараагийн бүлэгт “төрийн бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, дотоод хэрэгт үл оролцох” тухай заасан байна.¹²

Эдгээрээс үзвэл ШХАБ нь Хятад-Оросын хоорондын “Стратегийн түншлэл”-ийн бүс нутгийн хүрээн дэх гадаад бодлогын практик

хэрэгжилт төдийгүй Хятадын аюулгүй байдал, гадаад бодлогыг хэрэгжүүлэх нэгэн талбар гэж тодорхойлж болохоор байна.

4. Хятад, Орос хоёр чухам яагаад Монголыг ШХАБ-д элсүүлэхийг зорих болов?

Монгол Улсыг ШХАБ-д гишүүнээр элсэж орохыг Хятад болон Оросын талаас удаа дараалан шаардаж байгаа тухай Монголын дипломатууд олонтаа ярьж байгаа бөгөөд Монгол Улс ч уг байгууллагад элсэхийг хүсч байна гэх мэт мэдээллүүд гадаадын хэвлэлүүдээр мэдээлэгдсээр ирсэн.

Хятад, Орос хоёр улс Монголыг ШХАБ-д элсүүлэхийг зорьж буй нь дараах хэдэн шалтгаантай байхыг үгүйсгэхгүй юм.¹³

Нэгдүгээрт, “Монголын гадаад бодлогыг Америкийн тал руу хэт хэлбийхээс сэргийлж, Хятад Оросын үндэсний аюулгүй байдлын нийтлэг хэрэгцээ шаардлага”¹⁴-ыг хангахад чиглэж байна гэж хэлж болно. Үүнтэй холбогдуулан нэг жишээ дурдвал, Хятадын төрийн тэргүүн Ху Жиньтао 2003 оны 6 сард Монгол Улсад айлчлахдаа “Өөрийн нутагт гадаадын цэргийг байрлуулахгүй байх тухай Монгол Улсын бодлогыг дэмжиж” буйгаа илэрхийлсэн нь санаандгүй явдал биш болов уу.

Хоёрдугаарт, Монгол, Хятад хоёр улс хоёр талын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хоёр талын гэрээнүүдээр хэдийн хүлээн зөвшөөрсөн хэдий ч Хятадын тал 1990 оны ардчилсан хувьсгалын дараа Монголд өрнөсөн үндэсний үзлийн сэргэлт нь хил залгаа оршин суугаа үндэс нэгт Өвөр Монголчуудад нөлөөлж, энэ нь Хятадын “улс төр, нийгмийн тогтвортой байдал болон нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын батлан хамгаалах аюулгүй байдлыг хангахад”¹⁵ саад болох бөгөөд тэр нь үндэсний салан тусгаарлах үзлийг дэврээнэ гэж үзэж байгаатай холбоотой болов уу.

Гуравдугаарт, Хоёр орны худалдаа эдийн засгийн харилцааг улам бүр өргөжүүлэх зорилготой гэж хэлж болно. Өнөөдөр Хятад улс Монголын хамгийн том худалдааны түнш орон бөгөөд хоёр орны худалдааны нийт эргэлт 2003 оны байдлаар 448,3 сая ам.доллар, Монголын экспортын 46,1%, импортын 21,8%-ийг Хятад улс эзэлж байгаа билээ.

5. Монголын дипломатын хөзөр буюу “Буфер” улсын онцлог

Газар зүйн байрлалын хувьд их гүрнүүдийн хооронд оршиж, тэдний хоорондын зөрчил мөргөлдөөнийг зогсоох, зөөлрүүлэх үүрэг бүхий жижиг улсыг буфер улс гэдэг. Жишээ нь Люксембург, Швейцари зэрэг улс Герман, Францын хооронд “Буфер” улс болдог.

Дээр өгүүлсэн Японы Такүшёку их сургуулийн профессор Икэда Норихико хэлэхдээ “Олон улсын улс төрийн тавцан дахь Монгол Улсын

онцлог бол буфер улс байгаад оршино” гэжээ.¹⁶ Тэрээр “Монгол Улс энэхүү онцлог байдлаа ашиглаж чадах уу үгүй юу? гэсэн салаа замын уулзвар дээр ирээд байна”¹⁷ гэжээ. Илтгэгч үүнтэй санал нэгтэй байгаа бөгөөд тийм ч учраас өөрийн илтгэлээ “Монголын дипломат бодлогын шинэ сонголт” гэж нэрлэсэн билээ.

Монгол Улсын хувьд “Буфер”-ын онцлог нь шинэ зүйл огт биш бөгөөд ХХ зууны Монголын түүх энэ онцлогийг тод томруун харуулсан гэж хэлж болно. 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнөөс хойш монголчууд улс төр, эдийн засгийн хувьд бусдын хараат бус бие даасан “жинхэнэ тусгаар тогтносон” улс байхыг эрхэмлэн зорьж ирсэн билээ. Гэвч түүхийн их нугачаа, хоёр их гүрний болон бусад том гүрнүүдийн улс төр стратегийн сонирхол зэргээс шалтгаалан “Хэлбэр төдий тусгаар тогтнолоо” хамгаалан авч үлдсэн боловч “жинхэнэ тусгаар тогтнол”-оо олж чадаагүй билээ. Хүйтэн дайны дараагаар бий болсон олон улсын нөхцөл байдал монголчуудад түүхэн сонголт хийх боломж олгов. Энэ сонголтыг хэрхэн хийхээс Монголын улс төр, эдийн засгийн бие даасан байдал, арав гаруйхан жилийн настай Монголын нялх ардчиллын хувь заяа шийдэгдэнэ гэж хэлэхэд хилсдэхгүй болов уу.

ШХАБ-д элссэнээр Монгол Улсын эрх ашигт нөлөөлж болох сөрөг хүчин зүйлүүд:

Нэгдүгээрт: ШХАБ-д элсэж орсоноор Монгол Улс Хятад, Оросын улс төрийн хараат байдалд орох магадлал ихтэй.

Хоёрдугаарт: Монголын эдийн засгийн гадаад харилцаа ихээхэн улс төржих, аль эсвэл бие даасан байдлаа алдаж, Хятадын эдийн засгийн хараат байдалд аажмаар татагдан орох магадлал өндөр.

Гуравдугаарт: Төв Азийн Лалын экстремизм зэрэг шашны элдэв мөргөлдөөнд Монгол Улс татагдан орохгүй гэсэн баталгаагүй.

Дөрөвдүгээрт: ШХАБ-ын гишүүн ихэнх орнуудад авторитар дэглэм өнөөг хүртэл эрч хүчээ хадгалсаар байгаа бөгөөд энэ нь Монголын ардчиллын цаашдын хөгжилд шийдвэрлэх нөлөө үзүүлээд зогсохгүй олон улсын тавцан дахь Монголын нэр нөлөө, цаашлаад Монголд үзүүлэх гадаадын зээл тусламжид зохих хэмжээгээр нөлөөлөхийг үгүйсгэхгүй.

Тавдугаарт: их гүрнүүдийн аль нэгний эрх ашигт үл нэгдэж, бие даасан статусаа хадгалсанаар их гүрнүүдийн хооронд хүчний тэнцвэрийг хадгалах “Буфер” (buffer zone) улсын онцлог буюу Монголын хувьд цорын ганц “дипломатын хөзрөө” алдахад хүрнэ.

Тэгвэл Монголын эрх ашигт нийцсэн аюулгүй байдлын шинэ бүтцийг хэрхэн бий болгох вэ?

Моори профессор Зүүн Азийн хамтын ажиллагаанд оролцоходоо Монгол Улс ямар байр сууринаас хандвал зохистой байх талаар тодорхой саналуудыг дэвшүүлж байна. Тухайлбал, Хятад зэрэг эдийн

засаг, улс төрийн их гүрэлтэй өрсөлдөх, эсвэл Balance of power буюу их гүрнүүдийн хүчний тэнцвэрийг тэнцүүлэх замаар биш, Монголын онцлогыг харуулсан бүс нутгийн хамтын эрх ашигт нийцсэн тогтолцоог бий болгохыг чухалчилж байна. Профессорын энэ санал аюулгүй байдлын тогтолцоонд ч бас хамаарах болов уу гэж бодож байна.

Юуны өмнө дараах хэдэн алхмуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй болов уу гэж бодож байна. Үүнд: нэгдүгээрт, Give-and-take буюу харилцан эрх ашгийн тогтолцоонд тулгуурласан аюулгүй байдлын бүтцийг бий болгох нь чухал юм. Тухайлбал, Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг хууль эрх зүйн баталгаатай болгох хэрэгтэй. Энэ хүрээнд Монгол Улсаас цөмийн зэвсэгтэй хоёр хөрш оронтой байгуулах гурван талын гэрээ байгуулах үйл явцыг түргэтгэх нь чухал. Гурван талын гэрээний төслийг 2002 онд Орос-Хятадын талд гардуулсан боловч өнөөг хүртэл тодорхой үр дүн гараагүй байна.

Гурван талын гэрээ байгуулах асуудлыг 2 тал зарчмын хувьд зөвшөөрч байгаа байгаа бөгөөд ШХАБ Санктпетрбургын хурлаараа Монгол Улсын цөмийн зэвсэггүй бүсийн асуудлыг дэмжсэн бөгөөд 2000 онд НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн байнгын таван гишүүн аюулгүй байдлын улс төрийн баталгаа гаргаж өгсөн зэрэг олон талт дэмжлэгүүдийг цаг алдалгүй ашиглах нь стратегийн хувьд ихээхэн ач холбогдолтой юм.

Энэ мэт өөрийн орны болоод их гүрнүүдийн улс төрийн эрх ашгийг харилцан хангасан аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлэх нь Монгол мэт жижиг орон аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хангах хамгийн зөв сонголтын нэг байж мэдэх юм.

Хоёрдугаарт, 1994 оноос хойш бий болсон Монголын улс төрийн гадаад болон дотоод орчинд дүгнэлт хийж Монгол Улсын удаан хугацааны гадаад бодлогын үндсэн стратегийг нэн даруй боловсруулах шаардлагатай байна.

Монгол Улс 1994 онд аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хангах тухай үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалдаа тодорхой заасан хэдий боловч түүнийг хэрэгжүүлэх арга механизм, стратегийн үндсэн бодлого нь өнөөг хүртэл боловсрогдоогүй байна. Алс хэтийн тодорхой стратегийн бодлогогүй байгаагийн улмаас тухайн цаг үе, нөхцөл байдалд тааруулсан аль эсвэл Орос, Хятад зэрэг хөрш орнуудын бодлогод зохицуулсан туйлын прагматик шинжтэй гадаад бодлого явуулж байгаа нь хамгийн ноцтой бөгөөд аюултай үр дагаварт хүргэж мэднэ.

Гуравдугаарт, Гадаад бодлого стратегийн өндөр мэдээлэл, ур чадвар бүхий байнгын ажиллагаатай мэргэжлийн судалгааны байгууллагыг төрийн мэдэлд байгуулах хэрэгтэй.

Өнөөдөр үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үндсэн

чиглэлийг Гадаад хэргийн яам боловсруулж байгаа боловч яамны дотоодын болон УИХ, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлтэй уялдаа холбоо муу, мэдээллийн үндсэн сан, сүлжээ бий болоогүй байна.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Англиар Shanghai Cooperation Organization (SCO) гэдэг. Монголоор бичихдээ ШХАБ гэж товчлов.
2. “Асахи шинбүн” (Японы “Асахи сонин”) 2002.8.10.
3. Илтэгчийн өөрийн бичсэн уг илтэлийн тэмдэглэл. Уг илтэлийн видео бичлэгийг <http://www.jia.or.jp/web site-aac> үзнэ үү.
4. Икэда Норихико. Монгорү гайко-но киро то сэнтакү. “Жиюү” 43(9), 2001.9. 61-р хуудас./Салаа зам дээрх Монголын гадаад бодлого ба сонголт, “Чөлөөт байдал “сэтгүүл/
5. “Хигаши Ажиа сэнрякү гайкан 2001”, Бозэй кэнкюүжёо. /”Зүүн Азийн стратегийн тойм”, Японы Батлан хамгаалах хүрээлэн/
6. Хятадын “Ардын өдрийн сонин” 1999.5.12
7. Хятадын “Ардын өдрийн сонин” 1996.4.27
8. Кимура Хироши. Стратегийн түншлэлийн цаад учир. Японы “Токио сонин” 1998.8.23
9. Хятадын “Ардын өдрийн сонин” 2001.6.16
10. “Joint Statement of Kazakhstan, China, Kyrgyzstan, Russia and Tajikistan on the Almaty Meeting, July 3, 1998” <http://russia.shaps.hawaii.edu/fp/russia/joint-statement980703.html>, 2001.12.8 23:300
11. “Bishkek Statement, 25 Aug 1999” <http://russia.shaps.hawaii.edu/fp/russia/bishkek-19990825.html>, 2001.12.8 23:300
12. “Declaration on the Creation of the Shanghai Cooperation Organization” http://russia.shaps.hawaii.edu/fp/russia/sco_1_20010620.html, 2001.12.8 23:300
13. “Санкей шинбүн” (Японы “Санкей сонин”), 2001.6.15, “Асахи шинбүн” (Японы “Асахи сонин”) 2002.1.6.
14. Ван Хайся. Америк Монгол хөзрөөр тоглохоос сэрэмжил “Стратеги судлал” 2002.2-3, 151-р хуудас.
15. Дээрх өгүүллийн 154-р хуудас.
16. Икэда Норихико дээрх өгүүллийн 69-р хуудас.
17. Дээрх өгүүллийн 70-р хуудас.